



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 07 сарны 25 өдөр

Дугаар А/338

Мандалговь

Г

Гэрээ байгуулах тухай

Г

Монгол Улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, Засаг даргын 2018 оны А/293 тоот захирамжаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих "Цагаандэлгэр сумын Цэцэрлэгийн барилгын хүчитгэл"-ийн ажлын гүйцэтгэгчээр "БАЯНДЭ" ХХК-ийг сонгон 63,920,631 (Жаран гурван сая есөн зуун хорин мянга зургаан зуун гучин нэг) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Батлагдсан зураг төсвийн дагуу ажлыг чанартай гүйцэтгэн хүлээлгэж өгөхийг "БАЯНДЭ" ХХК-ний гүйцэтгэх захирал (Ц.Мөнхбаатар)-д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газрын дарга (Э. Чагнаадорж), Цагаандэлгэр сумын Засаг дарга (Д.Буджав) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГ



Ж. МӨНХЧУЛУУН

480010006